

REACH

Small and Medium Enterprise Access to Credit

REACH CAP ТУТМЫН СОНИН

2017 оны 11 сар №19

ЭНЭ УДААГИЙН ДУГААРТ:

1. АНУ-ын ОУХА-ийн REACH Төслийн форум амжилттай зохион байгуулагдлаа
2. Амжилтын түүх
3. Зээлийн боловсрол: Зээлээ дахин санхүүжүүлэхэд анхаарах зүйлс
4. Таны мэдлэгт булан: Зээлийн сайн түүх бүрдүүлэхийн ач холбогдол
5. Монгол улсад хэрэгжиж буй олон улсын байгууллагуудын төслүүд
6. Зээлийн зөвлөгөө: Валютын Зээл
7. Салбаруудад болсон онцлох үйл явдлуудаас
8. Бизнес ба Маркетинг
9. REACH Төслийн 12 сард зохион байгуулах үйл ажиллагааны хөтөлбөр

ХОЛБОО БАРИХ:

REACH Төслийн оффис:

№ 703, МАКС Тауэр,
Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс
☎ +(976) 7722-2210
✉ reach@dsmongolia.org
🌐 www.dsmongolia.org
📘 www.facebook.com/REACHProject

Баян-Өлгий Оффис:

№ 202 тоот, Гурван-Эрдэнэ Төв
5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг
☎ Утас: 7042-2080

Дорнод Оффис:

№ 11 тоот, Ольхон Худалдааны Төв,
9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг
☎ Утас: 7058-2030

Дундговь Оффис:

№ 205 тоот, Мандал Шилтгээн ХХК-ийн
байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан сум,
Дундговь аймаг
☎ Утас: 7059-2209

Сэлэнгэ Оффис:

№ 1 тоот, Алтан Булаг Төв
Сүхбаатар сум, 2-р баг, Сэлэнгэ аймаг
☎ Утас: 7036-3440

1. АНУ-ын ОУХА-ийн REACH Төсөл "Түншлэлийн хүрээнд Жижиг, Дунд Бизнесүүдийн Санхүүжилтийг Дэмжих нь" сэдэвт форумыг хоёр дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.

2017 оны 10 сарын 25, Лхагва гарагт-АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн зүгээс Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй REACH Төсөл "Түншлэлийн хүрээнд Жижиг, Дунд Бизнесүүдийн Санхүүжилтийг Дэмжих нь" сэдэвт форумыг хоёр дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.

Энэхүү форумын зорилго нь жижиг, дунд бизнесийн зээлжих чадавхыг сайжруулахад тооцоололтой, тогтвортой, шинэлэг арга замуудыг оролцогч талуудын түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд бий болгоход оршиж байна.

Тус форумын үйл ажиллагаанд АНУ-ын Элчин Сайдын Яам, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон Монгол улсын Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам, Үндэсний Хөгжлийн хороо, Зээлийн Батлан Даалтын Сан, Монгол Банк зэрэг төрийн байгууллагууд болон АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн REACH Төсөлтэй хамтран ажиллаж буй арилжааны банкнууд, олон улсын төсөл, хөтөлбөрүүд, их, дээд сургуулиуд, бизнес хөгжлийн байгууллагууд болон бизнес эрхлэгчид оролцож илтгэл тавилаа. Тус форум нь жижиг, дунд бизнесүүдийн зээлжих чадавхыг нэмэгдүүлэхэд төрийн болон зээл олгогч байгууллагуудын оролцоо, судалгааны байгууллагуудын оролцоо гэсэн үндсэн хоёр сэдвийн хүрээнд явагдсан бөгөөд зээл санхүүжилт олж авах, зээл авах үйл явцыг илүү хялбаршуулах арга замыг бий болгож, жижиг, дунд бизнесийн орчинд зээлжих чадавхыг нэмэгдүүлэх боломжийн талаар хэлэлцсэн томоохон арга хэмжээ боллоо.



2. АМЖИЛТЫН ТҮҮХ



Бизнесийн салбар:

Модон эдлэл үйлдвэрлэл

Бизнесийн нэр:

Жасмин Вүүд ХХК

Бизнес эрхлэгчийн овог, нэр:

Гомбосүрэн овогтой Энхбаяр

Гомбосүрэн овогтой Энхбаяр нь 2010 оноос эхлэн хувиараа захиалгын дагуу тавилга хийдэг байсан тэрээр хагас жилийн өмнөөс Жасмин вүүд ХХК нэрийн доор үйл ажиллагаагаа явуулж байна. Түүний хувьд энэхүү бизнест хөл тавьсан түүх сонирхолтой. Тэрээр Солонгос улсад гэрээгээр ажиллаж байхдаа тавилгын үйлдвэрт ажиллаж байсан тул Монголд эргэж ирсэн тухайн үед өөрийнхөө гэрт тавилга хийж тохижуулснаар түүний ойр хавийн хамаатан, найз нөхөд нь ч тавилга хийлгэх санал тавьснаар ажлын хажуугаар тавилга хийх захиалга авдаг болсноор өнөөдрийн компанийг бий болгож, одоогоор өөрийн гэсэн үйлдвэрээ барьж байна. Тэрээр үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, үйлдвэрлэсэн тавилга нь өөрийн гэсэн брэнд болж чаджээ.

Г.Энхбаяр нь бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор тоног төхөөрөмж авах төслийн зээлд хамрагдах хүсэлтэй байсан

тул Голомт банкны эдийн засагчтай холбогдсоноор АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг /ОУХА/-ийн REACH Төсөлтэй холбогдох боломж бүрдсэн юм. Тэрээр REACH Төсөлд хандсанаар тогтмол явагддаг уулзалтад хамрагдаж бизнес, санхүүжилтийн талаарх мэдлэгээ ахиулж, төслийн зээлийн зуучлалын үйлчилгээний үр дүнд санхүүжилтэд хамрагдаж чадсан юм.

“АНУ-ын ОУХА-ийн REACH Төслийн зээлийн зуучлалын үйлчилгээний үр дүнд санхүүжилтэд хамрагдаж чадлаа. REACH Төслийн хамт олонд баярлалаа. Амжилт хүсье.”

Цаашид Г.Энхбаяр авсан зээлээрээ үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэн орлогоо нэмэгдүүлэх тал дээр анхааран ажиллахаас гадна REACH Төсөлтэй байнгын холбоотой хамтран ажиллаж байна




3. ЗЭЭЛИЙН БОЛОВСРОЛ

ЗЭЭЛЭЭ ДАХИН САНХҮҮЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

Хэрэв та олон зээлтэй бол дахин арай бага хүүтэй зээл авч өмнөх зээлүүдээ дахин санхүүжүүлэх буюу өмнөх зээлүүдээ төлөхөд ашиглаж болно. Үүнийг зээлээ дахин санхүүжүүлэх гэдэг.

Одоогийн зээлэндээ төлж буй хүүнээс бага хүүтэй зээл авч чадвал энэ нь дараах давуу талтай. Үүнд:

- Та нийтдээ бага хүү төлөх боломжтой боллоо гэсэн үг.
- Ерөнхийдөө олон зээлтэй байснаас нэг зээлтэй байсан нь дээр.



ЗӨВЛӨМЖ

Одоогийн зээлээ дахин санхүүжүүлэх эсэхээ шийдэхийн тулд урьдчилан сайтар судалгаа хийгээрэй. Одоогийн зээлээ дахин санхүүжүүлснээр таныг өр зээлээсээ салахад тусална, эсвэл хэчнээн их өр зээлтэй байсан ч танд тусална гэх мэт бодитой бус амлалт өгч буй аливаа зээлдүүлэгчдээс зайлсхийгээрэй.

Энэ шийдвэрийг гаргахаас өмнө, бага хүүтэй зээлийг ямар хугацаатай, нөхцөлтэй санал болгож буйг лавлаарай. Бага хүүтэй зээлийн нөхцөлийн талаар (аливаа шимтгэл, суутгал гэх мэт) судалж мэдээрэй. Түүнчлэн одоогийн зээлүүдээ хугацаанаас нь өмнө төлбөл зээлдүүлэгчид аливаа шимтгэл суутгал тооцож авах (хэрэв “тийм бол”, хэчнээн хэмжээтэй) эсэхийг асуугаарай. Эдгээр асуултын хариулт, таны одоо байгаа зээлүүдийн нөхцөлүүд болон шинэ зээлийн нөхцөлөөс шалтгаалан тухайн шинэ зээлийн хүү одоо байгаа зээлүүдийн хүүнээс бага ч гэсэн зээлээ дахин санхүүжүүлэх нь таныг санхүүгийн хувьд дордуулж ч болох юм.

Зээлээ дахин санхүүжүүлэх нь таныг илүү их мөнгө зээлэх хүсэлд автуулж, улмаар илүү их өр зээлд унагахаас болгоомжлох хэрэгтэй. Жишээлбэл, хэрэв та кредит картыхаа зээлийн үлдэгдлийг өөр зээл рүү шилжүүлж чадвал тухайн кредит картаас дахин зээл авах хүсэл төрж болох магадлалтай. Хэрэв зээлээ дахин санхүүжүүлэх нь таны нийт өр зээлийн хэмжээг нэмэгдүүлж байвал энэ нь таны санхүүгийн нөхцөл байдлыг улам дордуулж байгаа явдал юм.

Хэрэв та эцэст нь илүү их мөнгө төлж (зээлийн хүү, шимтгэл, суутгал гэх мэт), мөнгө алдаж, санхүүгийн хувьд улам дордож байгаа буюу мөнгө хэмнэхгүй л бол зээлээ дахин санхүүжүүлэх хэрэггүй.

Та авсан зээлээ эргүүлэн төлж чадахгүй хэцүү байна уу?

Та зээлээ эргүүлэн төлж чадахгүй, эсвэл зээлийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг асуудлыг үл ойшоон “бүх зүйл болох биз дээ” гэж тайвшраад орхиж болох ч БҮҮ ИНГЭЭРЭЙ. Хэрэв та зээлээ эргүүлэн төлөхтэй холбоотой асуудлыг үл ойшоовол уг асуудал хэзээ ч дээрдэхгүй харин ч улам дордоно!


Эх сурвалж: <http://www.sankhuuginbolovsrol.mn>

4. ТАНЫ МЭДЛЭГТ

ЗЭЭЛИЙН САЙН ТҮҮХ БҮРДҮҮЛЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Арилжааны банкнууд зээлдэгчийн зээлдэгчийн зээлээ цаг хугацаандаа төлж байгаа байдлаас хамааруулан зээлдэгчдээ үнэлгээ өгдөг ба энэ мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулж өгдөг. Зээлийг ашиглах хугацаанд зээлээ гэрээний дагуу төлж байсан болон хугацаа хэтрүүлж байсан хоногоос хамааруулан энэхүү үнэлгээ өгч байдаг. Өөрөөр хэлбэл, таны банкнаас авсан зээлийн ерөнхий мэдээлэл, эргэн төлөгдсөн байдал зэрэг мэдээллийг Монгол улсад үйл ажиллагаа явж буй бүх банкнууд нэгдсэн

зээлийн мэдээллийн сангаасаа авах боломжтой. Мөн банкнууд сүүлийн үед Скоринг буюу зээлжих чадварын үнэлгээг хийж зээлдэгчийн зээлжих чадвар, эрсдэлийн төвшинг тодорхойлох орчин үеийн арга хэрэгслүүдийг дотооддоо ашигладаг болоод байна. Ингэснээр сайн түүхтэй зээл хүсэгчийн цаг хугацааг хэмнэсэн, түргэн шуурхай үйлчлэх бүтээгдэхүүн үйлчилгээнүүд гарсаар байна. Мөн энэхүү үнэлгээгээ дараа дараагийн зээл олох эсэх, зээлийн нөхцөл болон зээлийн хэмжээ, хугацаа, хүүг тогтоохдоо ашигладаг. Өөрөөр хэлбэл, зээлээ цаг хугацаандаа төлж чадаж байвал банкны сайн зээлдэгч болж зээлдэгчийн сайн түүх бүрдүүлэх нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой гэсэн үг юм.



Эх сурвалж: <http://www.sankhuugjinbolovsrol.mn>

5. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИЖ БУЙ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭР, ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН БАТЛАН ДААЛТТАЙ ТӨСЛИЙН ЗЭЭЛ

ТА ЗЭЭЛЭЭР ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ?

Энэхүү зээл нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийг олгох зорилготой бөгөөд харилцагч та зээлээр үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх бол

ТАНД ЯМАР БОЛОМЖ, ДАВУУ ТАЛ БИЙ БОЛОХ ВЭ?

Зээлийн батлан даалтын сан (ЗБДС)-гийн батлан даалтад хамрагдан, хөнгөлөлттэй нөхцөл бүхий бизнесийн зээлийг банкны бүх салбарт хандан авах.

ИРГЭДИЙН ХУВЬД:

- Зээлийн өргөдөл (Банкны салбараас);
- Жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчээр бүртгүүлсэн гэрчилгээ эсвэл тодорхойлолт;
- Иргэний үнэмлэхийн хуулбар (зээлийг хамтран хариуцах хүнд мөн адил хамаарна);
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз (шаардлагатай тохиолдолд);
- Хэрэгжүүлэх төслийн танилцуулга (Загварыг банкны салбараас авна уу);
- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ /эх хувиар/;
- Санхүүгийн тайлан, тайлан гаргадаггүй бол орлогын бүртгэлийн дэвтэр (хар дэвтэр), дансны хуулга;
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцэл;
- Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд;
- Зээл хүсэгч иргэн, хамтран хариуцах этгээдийн нэр дээр авсан үл хөдлөх хөрөнгө эзэмшлийн дэлгэрэнгүй лавлагаа;
- Зээл хүсэгч иргэн, хамтран хариуцах этгээдийн нэр дээр авсан аж ахуй нэгж эзэмшдэг эсэх дэлгэрэнгүй лавлагаа;
- Бусад шаардлагатай баримт бичгүүд.

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ :

| Хамрах хүрээ | Жилийн борлуулалтын орлого 1.5 тэрбум төгрөгөөс дээшгүй жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэн |
|---|--|
| Зээлийн хэмжээ | 1 тэрбум төгрөг хүртэл |
| Зээлийн хүү | Жилийн 12%-15% |
| Зээлийн хугацаа | 10 жил хүртэл |
| Үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 24 сар хүртэл |
| Зээлийн үйлчилгээний шимтгэл | 0.15% |
| ЗБДС-н батлан даалтын хэмжээ | Зээлийн дүнгийн 30%-60% |
| ЗБДС-н батлан даалтын хураамж | 50,000 төгрөгийг 1 удаа төлнө |
| ЗБДС-н батлан даалтын шимтгэл | Зээлийн үлдэгдлийн батлан даасан дүнгийн 1 хувиар тооцож жил бүр төлнө |

АЖ АХУЙН НЭГЖИЙН ХУВЬД:

- Зээлийн өргөдөл (Банкны салбараас);
- Жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчээр бүртгүүлсэн гэрчилгээ эсвэл тодорхойлолт;
- Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм;
- Зээл авах, компанийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавихыг зөвшөөрсөн хувь нийлүүлэгчдийн зөвшөөрөл;
- Компанийн удирдах ажилтны иргэний үнэмлэхийн хуулбар, анкет;
- Компанийн товч танилцуулга;
- Хэрэгжүүлэх төслийн танилцуулга (Загварыг банкны салбараас авна уу);
- Санхүүгийн тайлан (сүүлийн 1-2 жилийн);
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз (шаардлагатай тохиолдолд);
- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ /эх хувиар/;
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд;
- Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд;
- Зээл хүсэгч компани, хувь нийлүүлэгчдийн нэр дээр авсан үл хөдлөх хөрөнгө эзэмшлийн дэлгэрэнгүй лавлагаа;
- Бусад шаардлагатай баримт бичгүүд.

Эх сурвалж: <http://www.tdbm.mn/>

6. ЗЭЭЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

ВАЛЮТЫН ЗЭЭЛ

ЗЭЭЛ АВАХААС ӨМНӨ МЭДЭХ ЁСТОЙ ЗҮЙЛС

Ам.доллар, юань, евро гэх мэт гадаад валютаар зээл авах нь хүүгийн хувьд өнгөц харахад төгрөгийн зээлээс хямд бөгөөд ашигтай харагдаж болно. Гэвч валютын зээл нь валютын ханшийн өөрчлөлтөөс шууд хамаардаг тул таны сар бүр эргэн төлөх төлбөр өсч болзошгүй бөгөөд энэ талаараа эрсдэл өндөртэй санхүүгийн бүтээгдэхүүнд тооцогддог.



ВАЛЮТЫН ЗЭЭЛ **≡** **ЭРСДЭЛТЭЙ САНХҮҮЖИЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ**



ГАДААД ВАЛЮТЫН ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Валютын зээлийн хүү нь төгрөгийн зээлийн хүүгээс бага байдаг боловч валютын зээл нь хямд гэсэн үг биш юм.

Учир нь валютын ханшийг урьдаас тааварлах боломжгүй тул таны сард төлөх зээлийн төлбөр валютын ханшаас хамаарч өөрчлөгдөнө. Хэрэв төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларвал таны сард төлөх төлбөр төгрөгөөр өсөх болно. Тус өсөлт нь таны сарын орлогыг ч давах боломжтой.

ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ


Хэрэв та төгрөгөөр зээл авбал таны сард төлөх төлбөр тогтмол байна. Сар бүрийн зээлийн төлбөр валютын ханшаас хамаарч өөрчлөгдөхгүй.



ГАДААД ВАЛЮТЫН ЗЭЭЛ: ЭРСДЭЛ ӨНДӨР

- Харьцангуй бага хүү
- Сар бүрийн төлбөр валютын ханшаас хамааралтай
- Зээл урт хугацаандаа илүү өндөр өртөгтэй болж болзошгүй.

ЭРСДЭЛ ӨНДӨР



ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ: ЭРСДЭЛ БАГА

- Харьцангуй өндөр хүү
- Сар бүрийн зээлийн төлбөр валютын ханшаас хамаарахгүй
- Сар бүрийн зээлийн төлбөр тогтмол.



7. САЛБАНУУДАД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС

БАЯН-ӨЛГИЙ САЛБАР

REACH Төслийн Баян-Өлгий салбар 2017.10.13-нд “Санхүүгийн боловсрол олгох нь” сургалт Төрийн банкны сургалтын тэнхимд болов. Сургалтыг нээж Төрийн банкны захирал Х.Жанузах үг хэлж сургалтад оролцогчдод амжилт хүсэв. Сургалтад нийт 31 бизнес эрхлэгч оролцож санхүүгийн мэдээлэл авч өртөг хэрхэн тооцох, бизнесийн орлого мөнгөн урсгалыг зөв тооцох зэргээр дасгал ажиллаж үнэлэлт дүгнэлт өгсөн сургалт боллоо.



ДОРНОД САЛБАР

REACH Төслийн Дорнод салбар нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилтийг дэмжих, богино хугацаанд санхүүжилт олж авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2017.10.17-нд “Төслийн зээлд хамрагдах боломж” сэдэвт уулзалтыг Худалдаа Хөгжлийн Банк, Зээлийн Батлан Даалтын Сантай хамтран зохион байгууллаа. Үг уулзалтад 100 орчим бизнес эрхлэгчид оролцож МУ-д хэрэгжиж байгаа ОУ-ын төсөл хөтөлбөр болон АХБ-ны эх үүсвэр болон Зээлийн Батлан Даалтын сангийн батлан даалттай төслийн зээлийн талаарх мэдээллийг хүргэлээ.



ДУНДГОВЬ САЛБАР

REACH Төслийн Дундговь салбарт 2017.10.14-нд “Бизнес төлөвлөгөө боловсруулах үр чадвар олгох” сургалт зохион байгуулагдлаа. Сургалтаар “Бизнес төлөвлөгөөгөө хэрхэн зөв танилцуулж, санхүүжүүлэгч олж авах, нийгэмд чиглэсэн бизнесийг хэрхэн хийх талаарх мэдлэгийг олж авлаа. Сургалтыг онол практик хоослуулж өөрсдийн бизнес төлөвлөгөөний танилцуулгыг хийх замаар удирдан явууллаа.



СЭЛЭНГЭ САЛБАР

REACH Төслийн Сэлэнгэ салбар нь 2017-10-11-нд Сэлэнгэ аймгийн ЖДБ эрхлэгч нарт зориулан “Бизнес төлөвлөгөө хэрхэн боловсруулах” сэдвээр сургалт зохион байгууллаа. Үг сургалтаар бизнес төлөвлөгөө боловсруулах нь амжилттай бизнес эрхлэх гол зарчим өөрийн бизнесийг бизнес төлөвлөгөөтэй болгох мэдлэг мэдээлэлийг олж авлаа. Сургалтанд нийт 17 жижиг, дунд бизнес эрхлэгчид оролцов.



8. БИЗНЕС БА МАРКЕТИНГ



Шинэ хэрэглэгч авах зардал хэрхэн тооцоолох вэ: Тодорхой хугацаанд гарч буй нийт маркетинг, борлуулалтын зардлыг уг хугацаанд шинээр авсан хэрэглэгчийн тоонд хуваана.

Маркетинг, борлуулалтын зардал = Маркетинг, зар сурталчилгааны бүх төрлийн зардал + цалин + урамшуулал + бусад нэмэлт зардлууд (улирал, жилээр) Шинэ хэрэглэгчийн тоо = Тухайн хугацаанд шинээр авсан хэрэглэгчийн тоо (улирал, жилээр) Томъёо: маркетинг, борлуулалтын зардал ч шинэ хэрэглэгчийн тоо = Шинэ хэрэглэгч авах зардал Жишээ харцгаая: Маркетинг, борлуулалтын зардал = ₮120,000,000 Шинэ хэрэглэгчийн тоо = 300 ШХАЗ = ₮120,000,000 ч 300 = ₮400,000 хэрэглэгч бүрт ШХАЗ тооцох нь яагаад чухал гэж : ШХАЗ нь танай компани нэг шинэ хэрэглэгч олж авахдаа хэр зардал гаргаж байгааг харуулдаг. ШХАЗ бага байх тусам сайн. ШХАЗ өсч байвал нэг шинэ хэрэглэгч авахад илүү өндөр зардал гаргаад байна, танай маркетинг, борлуулалтын үйл ажиллагаа тийм ч үр дүнтэй бус байгааг илэрхийлнэ.

Эх сурвалж: "www.bzp.mn"

9. REACH ТӨСЛИЙН 12 САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улаанбаатар салбарт:

- 2017.12.07-нд "Жижиг дунд бизнес эрхлэгчдийн зээлжилтийг дэмжих нь" ажил хэрэгч уулзалт
- 2017. 12.12-14-нд "Бизнесийг төлөвлөх нь" сургалт

Орон нутгийн салбаруудад:

- 2017.12.09-нд Баян-Өлгий салбар, "Тооцоолох цаг-2" сургалт
- 2017.12.06-нд Дундговь салбар, "Зээлийн боловсрол олгох нь" сургалт
- 2017.12.13-нд Дундговь салбар, "Санхүүжилтийн эх үүсвэрийг олж авах нь" ажил хэрэгч уулзалт
- 2017.12.10-нд Дорнод салбар, "Санхүүгийн хяналтыг хэрхэн хийх вэ?" сургалт
- 2017.12.07-нд Сэлэнгэ салбар, "Бизнес төсөл боловсруулах үр чадвар олгох" сургалт
- 2017.12.12-нд Сэлэнгэ салбар, Өглөөний эртэч уулзалт
- 2017.12.19-нд Сэлэнгэ салбар, "Санхүүжилтийг дэмжих нь" ажил хэрэгч уулзалт

Та дээрх сургалт, уулзалтанд бүртгүүлэх бол:

- **Улаанбаатар Оффис:**
№: 703, МАКС Тауэр, Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Утас: 7722-2210, И-мэйл: reach@dsmongolia.org
- **Баян-Өлгий Салбар**
№ 202 тоот, Гурван-Эрдэнэ Төв 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг. Утас 7042-2080
- **Дундговь Салбар**
№ 205 тоот Мандал Шилтгээн ХХК-ийн байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан Сум, Дундговь аймаг. Утас 7059-2209
- **Дорнод Салбар**
№11 тоот, Ольхон Худалдааны Төв, 9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг. Утас 7058-2030
- **Сэлэнгэ Салбар**
№1 тоот, Алтан Булаг Төв, Сүхбаатар сум, 2-р Сэлэнгэ аймаг. Утас 7036-3440

"Энэхүү сониныг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр дэмжлэгтэйгээр бүтээсэн болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь сонинтой холбоотой хариуцлагыг бүрэн хүлээх бөгөөд үүнд АНУ-ын Засгийн Газар болон АНУ-ын ОУХА-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно."